



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт” /ДУА-2018-03-НА/

2018 оны 03 дугаар сар

Агуулга

Агуулга

Аудитын нэр, код

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт

Аудитын хамрах хүрээ

Үндсэн мэдээлэл

Эрсдлийн үнэлгээ

Аудитын арга зүй

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудит хийх хугацаа

Аудитын хөтөлбөр

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ

Хавсралт №2 Асуудлын шинжилгээ

Хавсралт №3 Аудитын арга зүй

Хавсралт №4 Аудитын хөтөлбөр

Хавсралт №5 Үр өгөөжийн төлөвлөлт

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор

Б.Төвсанаа



АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”

2. Аудитын код:

/ДУА-2018-03-НА/

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөл олголт болон түүнд тавих хяналт хууль журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд асуудлыг авч үзнэ. Үүнд:

- Орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрөл олголт хууль журмын дагуу явагдаж байна уу.
- Тусгай зөвшөөрлийн хяналт, үр дүнтэй байна уу.

5. Аудитын хамрах хүрээ:

Аймаг сумын ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний хүлээн авсан баримт материал, аймаг, сумдын эрх бүхий ажилтнуудын гаргасан тушаал, шийдвэрүүд, тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлын тэмдэглэл, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэнэ.

6. Үндсэн мэдээлэл

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар аймгийн Засаг дарга нь дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгодог. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
- Эмчилгээний гоо заслын үйлчилгээ
- Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх ашиглах

Харин сумын Засаг дарга нь дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгож байна. Үүнд:

- Агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах
- Тамхи худалдах

Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй нийт 40 сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүгд орсон нутгийн эмчийн байгууллага байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй 64 байгууллага байгаа бөгөөд үүнээс анхан шатлалын эмнэлэг 17 буюу 26.6 хувь, 2 дахь шатлалын эмнэлэг 1 буюу 1.6 хувь, эмийн эргэлтийн сан 17 буюу 26.6 хувь, эм ханган нийлүүлэх төв 9 буюу 14.1 хувь, үлдсэн 20 буюу 31.3 хувийг хувийн эмийн сан, бусад эмнэлэг, шүдний протез, ахуйн шавьж мэрэгч хорхойн ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ эзэлдэг байна.

Аймгийн нутаг дэвсгэрт тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 63 иргэн, аж ахуйн нэгж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 115 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог тухайн орон нутгийн 1000 хүн ам тутамд 2 – оос хэтрэхгүй байхаар заасан стандарт хэмжээтэй харьцуулж үзэхэд Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумд хэмжээндээ, 9 сум 27 цэгт байвал зохих хэмжээнээс илүү зөвшөөрөл олгож, 3 суманд стандарт хэмжээнээс 5-аар бага цэг үйл ажиллагаа явуулж байна.

Д/Д	Сумын нэр	Хүн амын тоо	Нормативаар байвал зохих цэгийн тоо	Одоо үйл ажиллагаа явуулж байгаа цэгийн тоо	Илүү дутуу	Тамхины цэгийн тоо
1	Адаацаг	2,925	6	6		3
2	Баянжаргалан	1,195	2	4	2	3
3	Говь-Угтаал	1,591	3	3		3
4	Гурвансайхан	2,149	4	5	1	3
5	Дэлгэрхангай	2,279	5	5		3
6	Дэлгэрцогт	1,677	3	4	1	4
7	Дэрэн	2,080	4	5	1	3
8	Луус	1,827	4	5	1	2
9	Өлзийт	2,352	5	3	-2	1

10	Өндөршил	1,421	3	4	1	1
11	Сайнцагаан	15,508	31	50	19	22
12	Сайхан-Овоо	2,180	4	3	-1	2
13	Цагаандэлгэр	1,047	2	3	1	2
14	Хулд	2,422	5	6	1	4
15	Эрдэнэдалай	5,730	11	9	-2	7
НИЙТ ДҮН		46,383	93	115	22	63

Аймгийн нийт хүн амын тоо 46,383 байгаа бөгөөд нормативаар 93 цэг байхаас одоо байгаа нь 115 цэг байгаагаас үзэхэд согтууруулах ундаа борлуулах цэгийн тоо 22-оор илүү байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөл олголтын хэрэгжилтэд хийх аудитын ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн. Дэлгэрэнгүйг Хавсралт №1-д үзүүлэв.

8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, арга зүйг мөрдөж, аймаг болон сумдын архи, тамхины тусгай зөвшөөрлийн олголт хариуцсан мэргэжилтэн болон бусад холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагаар орж асуулга тодруулга авч, нөхцөл байдлын шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, асуудлын шинжилгээ, үдшийн цайллагын арга зэрэг аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөрийн дагуу зохих горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Асуудлын шинжилгээг хавсралт №2-оор, Аудитын арга зүйг хавсралт №3-аар тус тус харуулав.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм журам, стандарт норматив зэргийг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Аудитын Олон Улсын стандарт;
- Төрийн аудитын тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль;
- Улсын тэмдэгийн хураамжийн тухай хууль;
- Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110 тоот тушаал;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 142 дугаар тогтоол;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 43 дугаар тогтоол.

12. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

- Аудитын явцыг хянан удирдах ажилтан:

Тэргүүлэх аудитор П.Төвсанаа
Аудитын менежер Х.Наранцацрал

- Аудит хийх аудиторууд:

Ахлах аудитор Д.Ихбаяр
Аудитор /А.Должинсүрэн /

13. Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 19-нд эхэлж, 2018 оны 04 дүгээр сарын 27-нд дуусгана.

14. Аудитын хөтөлбөр:

Аудитын хөтөлбөрийг хавсралт №4-д үзүүлэв.

15. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагын санал, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг аудитын зорилт тус бүрээр гаргана.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 2 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өгнө.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авах бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

а. Боловсон хүчин: Тэргүүлэх аудитор-1, Аудитын менежер-1, Нийцлийн аудитын баг-2, нийт 4 хүн, 49 өдөр 80 хүн/өдөр

б. Санхүүгийн нөөц, бүгд: 5,033.0 мянган төгрөг.

Үүнээс:

- Цалин хөлс 4,423.1 мянган төгрөг
- Дотоод томилот 322.6 мянган төгрөг.
- Тээврийн зардал 287.4 мянган төгрөг.

в. Техник, хэрэгсэл: компьютер, зөөврийн компьютер, принтер, диктафон, гэрэл зургийн аппарат, видео камер, хувилагч, скайнер,

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

Боловсруулсан:

Аудитын менежер

Ахлах аудитор

Х.Наранцацрал

Д.Ихбаяр



2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Асуудлын шинжилгээ

Хавсралт № 2

